



**“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022.3.11

№2022/07

Улаанбаатар хот

*2021 оны санхүүгийн тайлангийн талаарх  
Аудитын байгууллагын дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дахь заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь заалт, ТУЗ-ийн ээлжит хурлын шийдвэрийн дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. 2021 оны санхүүгийн тайлангийн талаархи “Grant Thornton ” ХХК-иас өгсөн Аудитын дүгнэлтийг “үндэслэлтэй” гэж хүлээн зөвшөөрч баталсугай.
2. 2021 оны санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг ХЭХ-д танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Х.Золжаргал/-д үүрэг болгосугай.
3. “Grant Thornton ” ХХК-иас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган, биелэлтийг улирал бүр ТУЗ-д танилцуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Золжаргал/, Санхүү Удирдлагын Газрын захирал /Д.Сувд/ нарт даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**

**Д.НЯМХҮҮ**




# САНХҮҮГИЙН ТАЙЛАН БА ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН



## Санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлан

### “Улаанбаатар БҮК” ХК

2021 оны 12 дугаар сарын 31



# Агуулга

|                                   |    |
|-----------------------------------|----|
| Хараат бус аудиторын дүгнэлт      | 3  |
| Санхүүгийн байдлын тайлан         | 6  |
| Орлогын дэлгэрэнгүй тайлан        | 8  |
| Өмчийн өөрчлөлтийн тайлан         | 9  |
| Мөнгөн гүйлгээний тайлан          | 10 |
| Санхүүгийн тайлангийн тодруулгууд | 12 |

## Компанийн талаарх мэдээлэл

|                             |   |             |
|-----------------------------|---|-------------|
| Компанийн нэр:              | "Улаанбаатар БҮК" ХК  |             |
| Үүсгэн байгуулах шийдвэр:   | 1996 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр анх үүсгэн байгуулагдсан.   |             |
| Төлөөлөн удирдах зөвлөлийн: | Дарга   | Д.Нямхүү    |
|                             | Гишүүд  | Д. Мөнхөө   |
|                             |   | Хамхоев,Х.Ю |
|                             |   | О.Басанхүү  |
|                             |   | Х.Золжаргал |
| Чаланов,М.А                 |   |             |
| Хараат бус гишүүн           | Громов,С.В  |             |
|                             | Г.Цогнэмэх  |             |
|                             | Т.Мэндсайхан  |             |
| Удирдлагын баг:             | Гүйцэтгэх захирал   | Х.Золжаргал |
|                             | Үйл ажиллагаа эрхэлсэн захирал  | Н.Хунцэнгэл |
|                             | Үйлдвэрлэл эрхэлсэн захирал   | Мирзоев,Р.Г |
|                             | Санхүү эрхэлсэн захирал   | Д.Сувд      |
|                             | Ерөнхий инженер   | Б.Нармандах |
|                             | Үйлдвэр техник технологийн дарга  | Б.С.Аларбек |
|                             | Ерөнхий нягтлан бодогч  | Б.Байнахүү  |
| Хаяг:                       | Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Дунд голын эрэг, "Улаанбаатар БҮК" ХК-ийн байр                     |             |
| Регистрийн дугаар:          | 2041219   |             |
| Үйл ажиллагаа:              | Угсармал орон сууцны бетон эдлэл хийх   |             |
| Ажиллагсадын тоо:           | 261   |             |
| Аудитор:                    | "Грант Торнтон Аудит" ХХК, Аудит, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зөвлөгөө, сургалт, үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага |             |

# Удирдлагын мэдэгдэл

Удирдлага нь санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусвар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу зохистой толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгох, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн.
- Компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
- Санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаанд үндэслэн бэлтгэсэн.
- Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, ирээдүйн үйл ажиллагаанд алдагдал хүлээж болзошгүй зүйлсийг байнга хянаж байх үүрэгтэй бөгөөд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага, болзошгүй зүйлсийн талаар тодруулсан.

"Улаанбаатар БҮК" ХХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Нямхүү, Гүйцэтгэх захирал Х.Золжаргал болон Ерөнхий нягтлан бодогч Б.Байнахүү бид энэхүү тайлангийн 12-36 дугаар хуудсанд үзүүлсэн компанийн санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



  
Гүйцэтгэх захирал  
Х.Золжаргал  
Огноо: 2022.03.04

  
Ерөнхий нягтлан бодогч  
Б.Байнахүү  
Огноо: 2022.03.04

## Хараат бус аудиторын дүгнэлт

### "Улаанбаатар БҮК" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

#### Дүгнэлт

Бид "Улаанбаатар БҮК" ХК (цаашид "компани" гэх) -ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангуудад (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- санхүүгийн байдлын тайлан,
- уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан,
- өмчийн өөрчлөлтийн тайлан,
- мөнгөн гүйлгээний тайлан болон
- нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр, "Улаанбаатар БҮК" ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав.

#### Хараат бус байдал

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

#### Аудитын аргачлалын хураангуй

|                       |  |
|-----------------------|--|
| Аудитын гол асуудлууд | Орлого хүлээн зөвшөөрөлт, хойшлогдсон татварыг мэргэжлийн шийдэл шаардсан, тооцоолол хийж байгаа зэргийг харгалзаж аудитын гол асуудалд тусгав.        |
| Аудитын цар хүрээ     | Компани нь охин компани, хараат компани эзэмшдэггүй учир энэхүү аудитын цар хүрээнд Компанийн нийтлэг зориулалттай санхүүгийн тайлан хвирагдсан болно. |

**Материаллаг байдал** Санхүүгийн тайлангийн аудитад ашигласан нийт материаллаг байдал нь 704,774.6 мянган төгрөг ба материаллаг байдлыг сонгохдоо нийт хөрөнгийн 1 хувиар тооцсон. Компанийн нийт хөрөнгийг суурь үзүүлэлтээр сонгосон шалтгаан нь компани үйлдвэр, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүчин чадалдаа түшиглэж гол үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд санхүүгийн тайлангийн үндсэн хэрэглэгч хувьцаа эзэмшигч нарын шийдвэр гаргалтад чухал нөлөөтэй гэж үзсэн. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг нийт материаллаг байдлын дүнгийн 75 хувиар буюу 528,580.9 мянган төгрөгөөр тогтоосон нь компанийн дотоод хяналтын орчинг дунд гэж үнэлсэнтэй холбоотой.

**Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхойгүй байдал**

Энэхүү санхүүгийн тайлангийн Тодруулга 2-д компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжийн талаар тусгасан.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

**Аудитын гол асуудал**

**Аудитын гол асуудалд авсан хариу арга хэмжээ**

**Орлого хүлээн зөвшөөрөлт**

Орлогыг зохих цаг хугацаандаа хүлээн зөвшөөрч бүртгэхгүй байх эрсдэлийг харгалзан үзэж аудитын гол асуудалд орууллаа. Орлогыг тохиролцсон барааг шилжүүлсэн болон ажил үйлчилгээг үзүүлэх гэрээний үүргээ биелүүлсэн бол тухайн мөчид хүлээн зөвшөөрнө.

Бид орлогын шинж чанарыг үнэлж, орлого бүртгэх хугацаа болон гэрээнд дурдсан аливаа онцгой шинжтэй нөхцөлүүдийг шинжилсэн.

Тайлант жилийн орлогын дүн 39,167,261.9 мянган төгрөг байна. Орлогын бүртгэлийн бодлого, тодруулгыг энэхүү тайлангийн тодруулга 4.12, тодруулга 17-д дурдсан.

Ингэхдээ бид орлогын дүнг гэрээтэй тулгаж, цар хүрээ, цаг хугацаа болон харилцагчтай үйлдсэн ажил эсвэл бараа хүлээлцсэн акт зэрэг рүү тулган шалгасан.

**Хойшлогдсон татвар**

Үр ашигт татварын хүүгийн түвшин өмнөх онд 18.5% байснаас 10% болж буурсан. Өөрчлөлтийн шалтгаан нь тайлант хугацааны борлуулалтын орлогын хэмжээ өмнөх оныхоос 26,265,110.1 мянган төгрөгөөр буурсантай холбогдож татварын өмнөх ашиг 6 тэрбум төгрөгөөс хэтрээгүй тул 10%-иар орлогын татвар тооцогдсонтой холбоотой.

Бид компанийн бодлогын хэрэгжилт, тайлант хугацааны болон хойшлогдсон татварын хяналт зэргийн зохистой эсэхийг удирдлагатай зөвшилцсөн.

Санхүүгийн байдлын тайланд тайлант хугацааны орлогын татварын авлага 96,331.1 мянган төгрөг, хойшлогдсон татварын өр төлбөр 446,650.8 мянган төгрөг тус тус байна. Дэлгэрэнгүй орлогын тайланд тусгасан 382,099.8 мянган төгрөгийн татварын зардал нь татварын өмнөх ашгийн 11%-ийг эзэлж байна. Тайлант хугацааны болон хойшлогдсон татварын үлдэгдлийг тодруулга 13-д харуулсан.

Бид тайлант хугацааны болон хойшлогдсон татварын тооцооллыг хийхдээ компанийн гүйцэтгэдэг процедур, холбогдох татварын тооцооллыг шалгасан.

Санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл, дүнг тодорхойлох шаардлагатай тооцооллын ач холбогдол зэргийг харгалзан үзээд тайлант хугацааны болон хойшлогдсон татварын үлдэгдлийг аудитын гол асуудал гэж үзсэн.

Компанийн хойшлогдсон татвартай холбоотой зөрүүг залруулах бичилтийг санал болгож, санхүүгийн тайланд залруулсан. Түүнчлэн хүлээн зөвшөөрөх зарчим зохистой эсэх, тодруулга хангалттай эсэхийг үнэлсэн.

### *Бусад мэдээлэл*

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин санхүүгийн тайлан болон манай аудиторын тайланг багтаахгүй. Жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлан гарсан өдрөөс хойш бидэнд нээлттэй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид аливаа хэлбэрээр баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.

Санхүүгийн тайланд бидний хийсэн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол дээр тодорхойлсон бусад мэдээлэл бидэнд нээлттэй болсон үед уншиж танилцах, ингэхдээ уг бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар бидний олж авсан мэдлэгтэй материаллаг хэмжээгээр харшилж байгаа эсвэл өөрөөр материаллаг байдлаар буруу илэрхийлэгдсэн эсэхийг авч үзэх юм.

### *Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага*

Компаний удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу тэтан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### *Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага*

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дөнгөжөө эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

*Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадаахгүй ямар цар хүрээнд авч үзсэн талаарх тайлбар*

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдал ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.



- Удирдлагын ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй, байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг бөгөөд санхүүгийн тайлангийн өрөмжийг толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахүйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц доголдлыг бөгөөд нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харицгаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд багасч үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад чухал асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дэглвэртэй учраас аудиторын тайландаа харилцажгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

#### **Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаар**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 92, 94-р зүйлд заасны дагуу сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс тогтоосон бусад мэдээлэл, Компанийн дүрэмд заасан бусад мэдээллийг тайлагнах үүрэгтэй бөгөөд тэдгээр зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Энэхүү Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон гэрээт ажлын Партнер нь Н.Эрдэнэцог болно.



**Б.ОСОРГАР АВ**  
УДИРДАХ ПАРТНЕР

Огноо: 2022.03.04



**Н.ЭРДЭНЭЦОГ**  
ГЭРЭЭТ АЖЛЫН ПАРТНЕР

Огноо: 2022.03.04

"Улаанбаатар БҮК" ХК  
 Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд  
 2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

## Санхүүгийн байдлын тайлан

| Мянган төгрөгөөр                        | Тодруулга | 2021 оны<br>12 сарын 31-<br>ний үлдэгдэл | 2020 оны<br>12 сарын 31-<br>ний үлдэгдэл |
|---|-----------|--|--|
| <b>Хөрөнгө</b>                          |           |  |  |
| <b>Эргэлтийн хөрөнгө</b>                |           |  |  |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө         | 7         | 1,421,548                                | 3,384,327                                |
| Дансны болон бусад авлага               | 8         | 3,345,014                                | 2,810,822                                |
| Бараа материал                          | 9         | 28,557,457                               | 20,635,919                               |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо           | 10        | 1,270,009                                | 951,911                                  |
| <b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>          |           | <b>32,594,028</b>                        | <b>27,762,979</b>                        |
| <b>Эргэлтийн бус хөрөнгө</b>            |           |  |  |
| Үндсэн хөрөнгө, цэвэр                   | 11        | 38,090,112                               | 38,981,357                               |
| Биет бус хөрөнгө, цэвэр                 | 12        | 17,478                                   | -  |
| <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>      |           | <b>38,107,590</b>                        | <b>38,981,357</b>                        |
| <b>Нийт хөрөнгө</b>                     |           | <b>70,701,618</b>                        | <b>66,744,336</b>                        |
| <b>Өр төлбөр ба эздийн өмч</b>          |           |  |  |
| <b>Өр төлбөр</b>                        |           |  |  |
| <b>Богино хугацаат өр төлбөр</b>        |           |  |  |
| Дансны болон бусад өглөг                | 14        | 17,359,423                               | 13,189,144                               |
| Урьдчилж орсон орлого                   | 15        | 685,015                                  | 81,418                                   |
| <b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b> |           | <b>18,024,438</b>                        | <b>13,270,562</b>                        |

## Санхүүгийн байдлын тайлан (үргэлжлэл)

| Мянган төгрөгөөр                      | Тодруулга | 2021 оны<br>12 сарын 31-<br>ний үлдэгдэл | 2020 оны<br>12 сарын 31-<br>ний үлдэгдэл |
|---------------------------------------|-----------|--|--|
| <b>Урт хугацаат өр төлбөр</b>         |           |  |  |
| Хойшлогдсон татварын өр               | 13        | 448,851                                  | 498,908                                  |
| <b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>  |           |  |  |
|                                       |           | <b>448,851</b>                           | <b>498,908</b>                           |
| <b>Өр төлбөрийн нийт дүн</b>          |           |  |  |
|                                       |           | <b>18,471,089</b>                        | <b>13,767,470</b>                        |
| <b>Эздийн өмч</b>                     |           |  |  |
| Хувийн өмч                            | 18.1      | 131,547                                  | 131,547                                  |
| Нэмж төлөгдсөн капитал                | 18.3      | 7,225,920                                | 7,225,920                                |
| Дахин үнэлгээний нэмэгдэл             | 18.5      | 27,885,132                               | 28,391,057                               |
| Хуримтлагдсан ашиг                    | 18.4      | 17,187,928                               | 17,228,342                               |
| <b>Эздийн өмчийн дүн</b>              |           |  |  |
|                                       |           | <b>52,230,527</b>                        | <b>52,976,866</b>                        |
| <b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b> |           |  |  |
|                                       |           | <b>70,701,616</b>                        | <b>66,744,336</b>                        |

Уг санхүүгийн байдлын тайланг 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдөр батлав:

Х.Золжаргал

Б.Байнахүү

Гүйцэтгэх захирал

Ерөнхий нягтлан бодогч

Хуудас 12-36-д харуулсан тодруулгууд нь энэхүү санхүүгийн байдлын тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

"Улаанбаатар БҮК" ХК  
 Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд  
 2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөө тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэржлэв)

## Орлогын дэлгэрэнгүй тайлан

| Мянган төгрөгөөр                             | Тодруулга | 2021 он           | 2020 он           |
|--|-----------|-------------------|-------------------|
| Орлого                                       | 17        | 39,187,262        | 65,432,372        |
| Өртөг  | 18        | 23,816,005        | 39,747,063        |
| <b>Нийт ашиг (алдагдал)</b>                  |           | <b>15,551,257</b> | <b>25,685,309</b> |
| Түрээсийн орлого                             | 19        | 208,274           | 392,885           |
| Бусад орлого                                 | 20        | 191,775           | 511,349           |
| Борлуулалт, маркетингийн зардал              | 21        | (96,810)          | (92,460)          |
| Ерөнхий ба удирдлагын зардал                 | 22        | (10,700,503)      | (7,714,446)       |
| Санхүүгийн орлого                            | 23        | 413               | 19,252            |
| Санхүүгийн зардал                            | 23        | (1,334,218)       | (3,357,236)       |
| Бусад зардал                                 | 24        | (219,050)         | (301,381)         |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)   | 25        | 2,809             | (347,442)         |
| <b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b> |           | <b>3,601,949</b>  | <b>14,795,630</b> |
| Орлогын татварын зардал                      | 26        | (382,100)         | (2,391,187)       |
| <b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>       |           | <b>3,219,849</b>  | <b>12,404,443</b> |
| <b>Орлогын нийт дүн</b>                      |           |                   |                   |
| Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)  |           | 0.02              | 0.09              |

Хуудас 12-36-д харуулсан тодруулгууд нь энэхүү орлогын дэлгэрэнгүй тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

"Улаанбаатар БҮК" ХК  
 Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд  
 2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

## Өмчийн өөрчлөлтийн тайлан

| Мянган төгрөгөөр   | Өмч            | Нэмж<br>төлөгдсөн<br>капитал | Хөрөнгийн<br>дахин<br>үнэлгээний<br>нэмэгдэл | Хуримтлагдсан<br>ашиг | Нийт дүн          |
|--|----------------|------------------------------|--|-----------------------|-------------------|
| <b>2020 оны 01 сарын<br/>01-ний үлдэгдэл</b>                                   | <b>131,547</b> | <b>7,225,920</b>             | <b>22,000,498</b>                            | <b>4,730,251</b>      | <b>34,088,216</b> |
| Няглан бодох<br>бүртгэлийн бодлогын<br>өөрчлөлтийн нөлөө,<br>алдааны залруулга | -              | -                            | 7,398,778                                    | (388,381)             | 7,010,397         |
| <b>Залруулсан үлдэгдэл</b>   | <b>131,547</b> | <b>7,225,920</b>             | <b>29,399,276</b>                            | <b>4,341,870</b>      | <b>41,098,613</b> |
| Тайланг үеийн цэвэр<br>ашиг (алдагдал)   | -              | -                            | -  | 12,404,443            | 12,404,443        |
| Зарласан ногдол ашиг   | -              | -                            | -  | (526,190)             | (526,190)         |
| Дахин үнэлгээний<br>нэмэгдлийн хэрэгжсэн<br>дүн                                | -              | -                            | (1,008,219)                                  | 1,008,219             | -                 |
| <b>2020 оны 12 сарын<br/>31-ний үлдэгдэл</b>                                   | <b>131,547</b> | <b>7,225,920</b>             | <b>28,391,057</b>                            | <b>17,228,342</b>     | <b>52,976,866</b> |
| Няглан бодох<br>бүртгэлийн бодлогын<br>өөрчлөлтийн нөлөө,<br>алдааны залруулга | -              | -                            | -  | (19,783)              | (19,783)          |
| <b>Залруулсан үлдэгдэл</b>   | <b>131,547</b> | <b>7,225,920</b>             | <b>28,391,057</b>                            | <b>17,208,579</b>     | <b>52,957,103</b> |
| Тайланг үеийн цэвэр<br>ашиг (алдагдал)   | -              | -                            | -  | 3,219,849             | 3,219,849         |
| Зарласан ногдол ашиг   | -              | -                            | -  | (3,946,425)           | (3,946,425)       |
| Дахин үнэлгээний<br>нэмэгдлийн хэрэгжсэн<br>дүн                                | -              | -                            | (705,925.00)                                 | 705,925               | -                 |
| <b>2020 оны 12 сарын<br/>31-ний үлдэгдэл</b>                                   | <b>131,547</b> | <b>7,225,920</b>             | <b>27,685,132</b>                            | <b>17,187,928</b>     | <b>52,230,527</b> |

Хуудас 12-36-д харуулсан тодруулгууд нь энэхүү өмчийн өөрчлөлтийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

## Мөнгөн гүйлгээний тайлан

| Мянган төгрөгөөр  | Тодруулга | 2021 он            | 2020 он           |
|---|-----------|--------------------|-------------------|
| <b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>              |           |                    |                   |
| <b>Мөнгөн орлогын дүн</b>                                 |           | <b>43,199,703</b>  | <b>67,585,822</b> |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого              |           | 42,938,183         | 67,494,088        |
| Бусад мөнгөн орлого                                       |           | 261,520            | 91,734            |
| <b>Мөнгөн зарлагын дүн</b>                                |           | <b>44,519,607</b>  | <b>65,671,671</b> |
| Ажиллагчдад төлсөн  |           | 5,390,579          | 2,251,210         |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн                    |           | 1,404,410          | 514,683           |
| Бараа материал худалдан авахад төлсөн                     |           | 28,919,984         | 58,140,320        |
| Ашиглалтын зардалд төлсөн                                 |           | 183,007            | 247,015           |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэглүүрт төлсөн    |           | 1,499,214          | 1,176,893         |
| Хүүний төлбөрт төлсөн                                     |           | 180,090            | 599,444           |
| Татварын байгууллагад төлсөн                              |           | 5,390,510          | 1,416,983         |
| Даатгалын төлбөрт төлсөн                                  |           | 898                | 20,008            |
| Бусад мөнгөн зарлага                                      |           | 1,570,937          | 3,305,335         |
| <b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b> |           | <b>(1,319,904)</b> | <b>1,914,151</b>  |
| <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>  |           |                    |                   |
| <b>Мөнгөн орлогын дүн</b>                                 |           | <b>413</b>         | <b>3,164,034</b>  |
| Бусдад олгосон зээл, мөнгөн үрьдчилгээний буцаан төлөлт   |           | -                  | 3,144,782         |
| Хүлээн авсан хүүний орлого                                |           | 413                | 19,252            |

"Улаанбаатар БҮК" ХК  
 Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд  
 2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

## Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

| Мянган төгрөгөөр  | Тодруулга | 2021 он            | 2020 он          |
|---|-----------|--------------------|------------------|
| <b>Мөнгөн зарлагын дүн</b>  |           | <b>493,796</b>     | <b>1,591,280</b> |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшижээд төлсөн                                  |           | 493,796            | 1,591,280        |
| <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b> |           | <b>(493,383)</b>   | <b>1,572,754</b> |
| <b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>                      |           |                    |                  |
| <b>Мөнгөн орлогын дүн</b>   |           | <b>5,099,800</b>   | <b>-</b>         |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан                   |           | 5,099,800          | -                |
| <b>Мөнгөн зарлагын дүн</b>  |           | <b>5,189,540</b>   | <b>895,702</b>   |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө                          |           | 5,099,800          | 884,360          |
| Төлсөн ногдол ашиг  |           | 89,740             | 11,342           |
| <b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>         |           | <b>(89,740)</b>    | <b>(895,702)</b> |
| Валютын ханшийн зөрүү   |           | (93,754)           | 9,980            |
| <b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>                                       |           | <b>(1,942,781)</b> | <b>2,601,183</b> |
| <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>               | <b>7</b>  | <b>3,364,327</b>   | <b>763,144</b>   |
| <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>              | <b>7</b>  | <b>1,421,546</b>   | <b>3,364,327</b> |

Хуудас 12-36-д харуулсан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

